

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/004/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мөрөн сум 2025 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatar@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
П.САНЛИГРЭНЧИН ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/308
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл Дулааны Станц ТӨХК -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд авлага данс 488.5 сая төгрөгөөр буурахад хэрэглэгчдэд үзүүлсэн хөнгөлөлт 144.3 сая төгрөг /НӨАТ-гүй/, Одкон холдинг ХХК-иас авах 24.5 сая төгрөгийн авлагыг Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Дугаар 102/ШШ2024/02642 шийдвэрээр хүчингүй болгож, өмнөх үеийн үр дүнд залруулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөвсгөл Дулааны станц ТӨХК нь 2023-2024 оны халаалтын улирлын ачааллын үе болох 2023 оны 12 болон 2024 оны 1,2 дугаар саруудад нийт халаах ёстой чадлын 60-70 хувийг халаасан боловч, хэрэглэгчээс төлбөрийг 100 хувь авсан байна. Аудитаар айл өрх болон хувийн аж ахуйн нэгжүүдийн нийт 144.3 сая /НӨАТ-гүй/ төгрөгийн төлбөрийг хөнгөлүүлэхээр шийдвэрлэсэн.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл Дулааны станц ТӨХК-д өргөтгөлийн ажлыг хийхээр Төрийн худалдан авах ажиллагааны газраас 19,623.9 сая төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалтын ажлыг цахим системээр зарлаж, МЭЗ ХХК 19,617.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарч, гэрээ байгуулсан байна.

6725022128

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	93,945,646.05	558,411,523.28
1.1.2	Дансны авлага	791,552,439.46	303,003,003.73
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	87,883,722.77	20,933,865.68
1.1.6	Бараа материал	812,853,961.42	664,231,330.95
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,786,235,769.70	1,546,579,723.64
1.2.1	Үндсэн хөрөнгө	30,704,091,150.50	29,765,207,303.21
1.2.2	Биет бус хөрөнгө	498,482,536.53	494,661,487.14
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	82,395,809.70	82,182,610.71
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	31,284,969,496.73	30,342,051,401.06
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	33,071,205,266.43	31,888,631,124.70
2.1.1.1	Дансны өглөг	484,539,334.84	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,994,870.25	8,825,079.24
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	496,534,205.09	8,825,079.24
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	82,395,809.70	82,182,610.71
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	82,395,809.70	82,182,610.71
2.2	Өр төлбөрийн нийт дүн	578,930,014.79	91,007,689.95
2.3.1	Төрийн өмч	33,981,526,313.42	33,981,526,313.42
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,334,309,479.71	3,334,309,479.71
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	462,450,000.00	462,079,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-5,286,010,541.50	-5,980,291,558.39
2.3.11	Эздийн өмчийн дүн	32,492,275,251.63	31,797,623,434.74
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	33,071,205,266.42	31,888,631,124.69

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,230,237,513.89	8,658,470,063.88
2	Борлуулалтын өртөг	8,159,549,279.34	10,012,045,568.51
3	Нийт ашиг (алдагдал)	70,688,234.55	-1,353,575,504.63
5	Хүүгийн орлого	0.00	2,131,989.93
8	Бусад орлого	803,192,718.38	1,932,617,805.08
9	Борлуулалт, маркетингийн зардал	377,097,422.84	547,879,441.13
10	Ерөнхий ба удирдлагын зардал	227,901,828.81	346,765,922.17
12	Бусад зардал	266,135,067.32	356,224,539.26
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,746,633.96	-669,695,612.18
19	Орлогын татварын зардал	274,663.40	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,471,970.56	-669,695,612.18
24	Орлогын нийт дүн	2,471,970.56	-669,695,612.18

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.42	0.00	0.00	3,155,701,953.17	0.00	3,155,701,953.17	-5,289,360,755.08	32,310,317,511.51
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	878,243.02	878,243.02
3	Загтруулсан үлдэгдэл	33,981,526,313.42	0.00	0.00	3,155,701,953.17		462,450,000.00	-5,288,482,512.06	32,311,195,754.53
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Зарласан нөгдөл ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	2,471,970.56	2,471,970.56
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн харгалзан дүн	0.00	0.00	0.00	178,607,526.54	0.00	0.00	0.00	178,607,526.54
9	2023 оны 12-р сарын	33,981,526,313.42	0.00	0.00	3,334,309,479.71	0.00	462,450,000.00	-5,286,010,541.50	32,492,275,251.63

31-ээрх үлдэгдэл									
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга									
10	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-24,585,404.71	-24,585,404.71	
11	Зарлуулсан үлдэгдэл	33,981,526,313.42	0.00	0.00	3,334,309,479.71	0.00	462,450,000.00	-5,310,595,946.21	32,467,689,846.92
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	-370,800.00	0.00	-370,800.00
15	Тайлант Уеийн цэвэр ашиг () алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-669,695,612.18	-669,695,612.18
16	Дахин үнэлгээний намагдлийн харэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.42	0.00	0.00	3,334,309,479.71	0.00	462,079,200.00	-5,980,291,558.39	31,797,623,434.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,836,170,481.09	11,836,170,481.09
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,846,400,631.42	9,846,400,631.42
1.1.4	Буцаан авсан албан татвар	56,817,365.28	56,817,365.28
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,932,952,484.39	1,932,952,484.39
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,539,924,549.80	10,539,924,549.80
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,730,849,591.00	2,730,849,591.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	927,126,000.00	927,126,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,559,380,838.86	2,559,380,838.86
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	906,825,049.76	906,825,049.76
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,382,107,988.28	2,382,107,988.28
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	823,460,607.40	823,460,607.40
1.2.9	Бусад мөнгөн зарлага	210,174,474.50	210,174,474.50
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,296,245,931.29	1,296,245,931.29
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	58,196,989.93	58,196,989.93
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	56,065,000.00	56,065,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	2,131,989.93	2,131,989.93
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	889,606,243.99	889,606,243.99
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	889,606,243.99	889,606,243.99
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-831,409,254.06	-831,409,254.06
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	370,800.00	370,800.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	370,800.00	370,800.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-370,800.00	-370,800.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	464,465,877.23	464,465,877.23
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	93,945,646.05	93,945,646.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	558,411,523.28	558,411,523.28

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилгот түвшний гүйцэтгэл

№	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он		Харьцуулалт				
				Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Аудитлагдсан гүйцэтгэл	2023 гүйцэтгэлээс	Аудитлагдсан ы дараа	Батлагдсан төл-өөс	
		Х	1	2		3	4		5	
Боловсруулсан	ДЭХ	мян.Га	82.9	83.3	84.2	84.2	1.3	-	0.97	
	Дотоод хувь	хувь	1.9%	1.9%	1.9%	1.9%	(0.0)	-	(0.00)	
1	Хэрэгцээний дулаан эрчим хүчний зарцуулалт	мян.Га	1.6	1.6	1.6	1.6	-	-	-	
	Эрчим хүч түгээлт	мян.Га	81.4	81.7	82.6	82.6	1.3	-	0.97	
Нийт орлого	Үйл ажиллагааны орлого	сая.төг	9,033.4	10,743.3	10,737.6	10,593.2	1,559.8	(144.4)	(150.08)	
	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	8,230.2	8,804.5	8,802.8	8,658.5	428.2	(144.4)	(146.08)	
2	Үүнээс: Санхүүжилт (Улсын төсвийн татас)	сая.төг	239.6	111.1	107.1	107.1	(132.5)	-	(4.01)	
	Нийт зардал	сая.төг	563.6	1,827.7	1,827.7	1,827.7	1,264.0	-	-	
3	Нийт зардал	сая.төг	9,030.7	11,343.6	11,262.9	11,262.9	2,232.2	-	(80.70)	
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал	сая.төг	8,990.7	11,198.8	11,155.8	11,152.6	2,161.9	(3.2)	(46.22)	
4	Үүнээс: Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	40.0	144.8	107.1	110.3	70.3	3.2	(34.49)	
	Татварын өмнөх ашиг/алдагдал	сая.төг	2.7	(600.3)	(525.3)	(669.7)	(672.4)	(144.4)	(69.38)	
5	Татварын дараах ашиг/алдагдал	сая.төг	2.5	(600.3)	(525.3)	(669.7)	(672.2)	(144.4)	(69.38)	
	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төг	1.00	1.06	1.05	1.06	0.1	0.01	0.01	
7	Нийт авлага	сая.төг	879.4	613.0	467.3	323.9	(555.5)	(143.4)	(289.06)	
	Үүнээс: ЭХ-ний бусад	сая.төг	765.56	613.0	460.8	301.96	(463.6)	(158.8)	(311.04)	
8	Нийт өглөг	сая.төг	113.9	-	6.6	21.98	(91.9)	15.4	21.98	
	Нийт өглөг	сая.төг	578.9	-	91.0	91.0	(487.9)	-	91.01	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 209.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 209.8 сая төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд:

1. Хөвсгөл Дулааны станц ТӨХК нь 2023-2024 оны халаалтын улирлын ачааллын үе болох 2023 оны 12 болон 2024 оны 1,2 дугаар саруудад нийт халаах ёстой чадлын 60-70 хувийг халаасан боловч, хэрэглэгчээс төлбөрийг 100 хувь авсан байна. Мөн иргэдээс ирүүлсэн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх талаар өргөдөл гомдлыг шийдвэрлээгүй байна. Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-т "стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангах";, 29.1.3-т "гэрээнд заасан үйлчилгээний түвшнийг хангах", 30 дугаар зүйлийн 30.1.5-д "эрчим хүчээр хангагч гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс эрчим хүч дутуу нийлүүлсэн, гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлт бүхий эрчим хүчээр хангаагүй бол эрчим хүчний төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх";, Дулааны эрчим хүч ашиглалтын гэрээний Гурав. Хангагчийн эрх, үүрэг хэсгийн 3.1-т " Эрчим хүчний тухай хууль, техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг найдвартай хангана", 3.4-т " Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн хүрээнд үйлчлүүлэгчийн өмнө зохих хариуцлага хүлээнэ", 3.7-д "Гэрээнд заасан хугацаанаас эхлэн дулааны эрчим хүчээр хангана. Халаалтын улиралд буюу тухайн оны 9-р сарын 15-аас 5-р сарын 15 дуустал дулааны эрчим хүчээр хангана" гэж заасныг тус тус зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Орлогын тайланд 49.9 сая төгрөгийн ерөнхий удирдлагын болон борлуулалт маркетингийн зардлыг ББӨртөгт бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын гуравдугаар бүлгийн 2. Борлуулалтын өртөг: "Аж ахуйн нэгжийн эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээс хамаарч борлуулалтын өртөгт худалдааны чиглэлийн аж ахуйн нэгжийн хувьд борлуулсан барааны өртөг, үйлдвэрлэл болон үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн хувьд борлуулсан бүтээгдэхүүний өртөг хамаарна. Борлуулалтын өртгийг борлуулалтын орлоготой нь уялдуулж санхүүгийн тайланд тодруулна", Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн НБББББ-ийн 137-1389 дугаар хуудас, 5.3. Зардлын бүртгэлийн тусгай бодлого хэсгийн 5.3.1.2-т "Борлуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг нь дулаан үйлдвэрлэн дулаан дамжуулах төвөөр дамжуулан хэрэглэгчдэд түгээж байгаа дулааны үнэ, түүнийг түгээх шугам тоноглолын ашиглалтын хэвийн байдлыг хангахад зарцуулагдсан нөөцийн бууралтууд байна" гэж заасанд тус тус нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Зураг, төсөв хийлгэх ажил гүйцэтгэхээр шалгарсан Крейтив Энержи инженеринг ХХК-тай гэрээ байгуулахдаа ирүүлсэн үнийн саналаас 1.0 сая төгрөгөөр илүү дүнгээр гэрээ байгуулж, төлбөрийг илүү шилжүүлсэн байна. Энэ нь Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны тайланд тусгасан гэрээний дүнгээс зөрүүтэй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 3.2 сая төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 3.2 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт хангаж ажиллаагүй зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, нийцлийн аудитын хүрээнд 1 зөвлөмжийг Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Цайны газрын сард төлөх түрээсийн төлбөрөөс 1.9 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны *"Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай"* 49 дүгээр тогтоолоор баталсан жишиг үнийг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Бүтэн-Оргил ХХК-аас 1800 ширхэг соса сола худалдан авсан гэж бүртгэсэн боловч тулган баталгаажуулалт хийхэд 1008 ширхгийг худалдан авч 1.3 сая төгрөгийг илүү шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө НӨАТ шингээгүй өртгөөр төлөвлөснөөс гэрээний гүйцэтгэл нь НӨАТ-ын дүнгээр зөрүүтэй тайлагнагдсан, Нүүрс худалдан авахаар 1,182.2 сая төгрөг *НӨАТ-гүй* төлөвлөсөн боловч, гүйцэтгэгч сонгон шалгараагүй байхад шууд худалдан авалт хийсэн, тайлант онд худалдан авахаар төлөвлөсөн нүүрсний төсөвт өртгөөс 100.9 сая төгрөгөөр хэтрүүлж худалдан авалт хийсэн, Эрдэнэтийн Дулааны цахилгаан станцаас гэрээ байгуулахгүйгээр 69.1 сая төгрөгийн нүүрс худалдан авсан, худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон шалтгааныг тодорхойлж баримтжуулаагүй, шууд худалдан авах гэрээ байгуулахдаа холбогдох хуульд заасан шаардлага хангахгүй гэрээ байгуулсан зэрэг зөрчил илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т *"Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ"*, 10 дугаар зүйлийн 10.12-т *"Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно"*, 32 дугаар зүйлийн 32.1-т *"Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ"*, 36 дугаар зүйлийн 36.1.3-т *"нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол"*, 36.1.4-т *"нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан ажлын нэмэлт ажлын өртөг анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрэхгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол"*, 39 дүгээр зүйлийн 39.3-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:", 48 дугаар зүйлийн 48.4: Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана: 48.4.7-д "тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл" гэж заасныг тус тус зөрчсөн, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөөгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Цайны газрын барилгыг түрээслүүлэхдээ 2021 онд сонгон шалгаруулалт явуулснаас хойш дахин сонгон шалгаруулалт зарлаагүй, гэрээний загварыг баримтлаагүй, гэрээг нийт 4 удаа сунгасан байна. Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 7-д "Түрээслүүлэгч болон түрээслэгчийн хоорондын харилцааг хууль тогтоомж, энэ журамд заасны дагуу байгуулсан түрээсийн гэрээгээр зохицуулна.", 8-д "Харин төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг зөвхөн нэг этгээдэд түрээслүүлэх бол түрээслэгчийг сонгон шалгаруулна.", Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний загварын 1.5-д "Түрээсийн гэрээг нэг хүртэл жилээр 2 удаа сунгаж болно. "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний сунгалтын хуудас"-аар гэрээний хугацааг сунгаж, гэрээ дүгнэсэн тэмдэглэл болон тооцоо нийлсэн актыг хавсаргана. Түрээсийн гэрээний сунгалтын маягт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно." гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар.

Илрүүлэлт:

- ❖ Хамтын гэрээний 6.4 дэх заалт нь эрчим хүчний сайдын 2016 оны 97 дугаар тушаалын 5.3 дахь заалттай нийцэхгүй байна.
- ❖ Тус байгууллага нь Ахмадын сан байгуулаагүй бөгөөд Хамтын гэрээний 6.2, 6.4, 6.10, 6.16, 6.20 дахь заалтуудад ахмад настанд үзүүлэх нийгмийн асуудлын талаар тусгасан байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөө, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэж заасанд нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай хуульд заасны дагуу ахмадын сан байгуулж, хамтын гэрээнд тусгасан ахмад настантай холбоотой зүйл, заалтуудыг шинэчлэн боловсруулж, байгуулах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Борлуулалтын хөнгөлөлт	1	158.8	1	158.8			1	158.8				
Илүү шилжүүлсэн авлага	1	1.1	1	1.1			1	1.1				
ЕУ болон Бм зардлыг ББӨ-д бүртгэсэн	1	49.9			1	49.9	1	49.9				
Дүн	3	209.8	2	159.8	1	49.9	3	209.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Түрээсийн төлбөрийн зөрүү	1	1.9	1	1.9								
Соса сола зөрүү	1	1.3	1	1.3								
Цайны газрын түрээсийг сонгон шалгаруулалтгүй 2 удаа сунгасан	1	0			1	0						
Дүн	3	3.2	2	3.2	1	0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахмад настны тухай хууль, хамтын гэрээний хэрэгжилт								
Ахмадын сан байгуулаагүй	1	0					1	0
Дүн	1	0						
Худалдан авах ажиллагааны тухай хууль								
Хуулийн хэрэгжилт хангалтгүй	1	0			1	0		
Дүн	1	0						
Нийт дүн	2	0			1	0	1	0